



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар 1/00

Бат-Өлзий сум

┌ Байгаль орчныг хамгаалах, нөхөн ┐
сэргээх арга хэмжээний зардал
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.18 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 19 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ногоон байгууламж хариуцах, ойжуулалт, бусад ажилд туслах 3 ажилтан ажлуулах арга хэмжээний зардалд 31,050,000 (гучин нэгэн сая тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Зардалд шаардагдах 31,050,000 (гучин нэгэн сая тавин мянга) төгрөгийг хуваарийн дагуу сар бүр зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4.Ойн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ногоон байгууламж хариуцах, ойжуулалт, бусад ажилд туслах 3 ажилтантай гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавин ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН